



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/359

Улаанбаатар хот

“Зөвлөх эмч” ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 11.2.2, 11.2.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэл, хүрээ шинэчлэн батлах тухай” А/242 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чадавхыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэнд хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, Улсын нэгдсэн төв эмнэлэгтэй хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан зөвлөх эмч нарыг ажиллуулж, эрүүл мэндийн эрчимт эмчилгээ, үйлчилгээг тасралтгүй үзүүлэхийг Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг), удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Л.Баярмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011102